



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 11 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 9¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“9¹ дүгээр зүйл. Хүүхдийн мөнгөн хуримтлал

9¹.1. 2022 оны төсвийн жилд Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд мөнгөн хуримтлал үүсгэх зорилгоор шаардагдах хөрөнгийг энэ хуулийн 7.1-д заасан тухайн жилийн эх үүсвэрээс олгоно.

9¹.2. Энэ хуулийн 9¹.1-д заасан шаардагдах хөрөнгийн хэмжээг Ирээдүйн өв сангийн тухайн жилийн төсвийн тухай хуулиар батална.

9¹.3. Ирээдүйн өв сангийн батлагдсан төсвийн дагуу хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгохтой холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

9¹.4. Хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсвэл сард нэг удаа хүсэлт гаргаж, энэ хуулийн 9¹.1-д заасан мөнгөн хуримтлалаас тухайн сард доор дурдсан хугацаанд дараах хувиар тооцож мөнгөн хэлбэрээр авах эрхтэй:

Д/д	Хамрах хугацаа	Мөнгөн хэлбэрээр олгох хувь
1	2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл	100 хувь
2	2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал	50 хувь

2 дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.3. Сангийн данснаас санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 7.1-д заасан орлогын эх үүсвэрийн тухайн жилийн гүйцэтгэлээс энэ хуулийн 9¹.1-д заасан хөрөнгийг мөнгөн хуримтлал үүсгэх зорилгоор Төрийн санд, үлдэх хэсгийг Ирээдүйн өв сангийн Монголбанкн дахь дансанд тус тус шилжүүлнэ.”

3 дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “жил бүрийн улсын төсөвт тусгаж” гэснийг “Ирээдүйн өв сангийн тухайн жилийн төсвийн тухай хуульд тусгаж” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “энэ хуулийн 9.1-д” гэснийг “энэ хуулийн 9.1, 9¹ дүгээр зүйлд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “улсын” гэснийг “нэгдсэн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР